



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/208

Мөрөн сум

Сумдын баяр наадмын хугацааг
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4, 2.6, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит бус XIII хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын Засаг дарга нарын саналыг харгалзан Тулгар төрийн 2231 жил, Их Монгол Улсын 816 жил, Ардын хувьсгалын 101 жил, Ардчилсан хувьсгалын 33 жилийн ойн Хөвсгөл аймгийн сумдын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хугацаа, байршлыг хавсралтаар баталсугай.

2. Сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан баталж, нийтийн хэв журмыг сахиулах, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг сумын Засаг дарга, аймгийн Онцгой байдлын газар, аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн Цагдаагийн газар, төрийн байгууллагын удирдлагуудад тус, тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 06
дугаар сарын 23 өдрийн А/208 дугаар
захирамжийн хавсралт

СУМДЫН БАЯР НААДАМ ТЭМДЭГЛЭХ ХУВААРЬ

№	Сумын нэр	Баяр наадам болох байршил	Сум байгуулагдсан ой	Тэмдэглэх хугацаа
1	Алаг-Эрдэнэ	Сумын төв /Манхан/	-	2022 оны 07 дугаар сарын 10,11,12-ны өдөр
2	Баянзүрх	Сумын төв /Бэлтэс/	-	
3	Галт	Сумын төв /Идэр/	-	
4	Жаргалант	Сумын төв /Оргил/	-	
5	Рашаант	Сумын төв/Цэнгэл/	-	
6	Рэнчинлхүмбэ	Сумын төв /Зөөлөн/	90,91	
7	Төмөрбулаг	Сумын төв /Жаргалант/	-	
8	Тосонцэнгэл	Сумын төв /Цэнгэл/	-	
9	Улаан-Уул	Сумын төв /Төгөл/	90,91	
10	Ханх сум	Сумын төв /Турт/	90,91	
11	Хатгал тосгон	"Хасгийн хаяа"	-	
12	Цагаан-Уул	Сумын төв /Жаргалант/	90,91	
13	Цагааннуур	Сумын төв /Гурвансайхан/	-	
14	Шинэ-Идэр	Сумын төв /Нүхт баг/	-	
15	Эрдэнэбулган	Сумын төв /Дуурга/	90,91	
16	Арбулаг	Сумын төв /Мандал/	90,91	
17	Бүрэнтогтох	Сумын төв /Баянхошуу/	90	2022 оны 07 дугаар сарын 14,15,16-ны өдөр
18	Тариалан	Сумын төв /Мандал, Бадрах/	90,91	
19	Их-Уул	Сумын төв /Сэлэнгэ/	90,91	
20	Түнэл	Сумын төв /Булаг/	70	
21	Цагаан-Үүр	Сумын төв /Булган/	90,91	
22	Цэцэрлэг	Сумын төв /Халбан, Агуйт/	90,91	
23	Чандмань-Өндөр	Сумын төв /Хөхөө/	90,91	